



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 1117

Мөрөн сум

Мал, амьтны гоц халдварт шүлхий
өвчний дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Улсын Онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны А/77 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын үйл ажиллагааг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн мөн оны 05 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтад хамрагдах мал, амьтны тоог нэгдүгээр, дээрх үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтын арга хэмжээний ажлын хэсгийг шуурхай зохион байгуулж, шаардагдах ажиллах хүн хүч, шатахуун, автомашинаар ханган явц, гүйцэтгэлд нь өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4. Дархлаажуулалтад хамрагдах малын тоо, шаардагдах вакцин, ариутгалын бодис, хамгаалах хувцас хэрэгслийг хуваарилан олгож, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, тайлан мэдээ, акт баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
4 дүгээр сарын 4 өдрийн А/117
захирамжийн нэгдүгээр хавсралт

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТАНД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО

РЮА0007 9070354

№	Аймаг	Сум	Үхэр	Гахай	Цаа буга
1	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	24454		
2		Арбулаг	24345		
3		Баянзүрх	27251		
4		Бүрэнтогтох	26337		
5		Галт	19357		
6		Жаргалант	17250		
7		Их-Уул	21076	56	
8		Мөрөн	20781	41	
9		Рашаант	12961	31	
10		Рэнчинлүмбэ	29373		
11		Тариалан	23684	360	
12		Тосонцэнгэл	20967		
13		Төмөрбулаг	21458		
14		Түнэл	30482		
15		Улаан-Уул	30767		7
16		Ханх	17991		
17		Хатгал	13348		24
18		Цагааннуур	4245		2417
19		Цагаан-Уул	31455		
20		Цагаан-Үүр	13168		
21		Цэцэрлэг	18948		
22		Чандмань-өндөр	23234		
23		Шинэ-Идэр	13976		
24		Эрдэнэбулган	20626		
		Дүн	503539	534	2448

Аймгийн Засаг даргын 2022 оны
4 дүгээр сарын 14 өдрийн А/117
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХУВААРЬ

№	Ажлын хэсэг	Сум	Ажиллах байгууллага
1	1-р хэсэг	Төмөрбулаг	Багийн ахлагч: Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Эрхэмбаяр Гишүүд: Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахмад Ц.Энх-отгон Мэргэжлийн хяналтын газрын Мал үржлийн хяналтын улсын байцаагч Ц.Эрдэнэ Мал эмнэлгийн газрын малын их эмч С.Болорчулуун
2		Шинэ-идэр	
3		Галт	
4		Жаргалант	
5	2-р хэсэг	Бүрэнтогтох	Багийн ахлагч: Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Түмэнбаяр Гишүүд: Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахлах дэслэгч Н.Эрдэнэбилэг. Мал эмнэлгийн газрын Лабораторийн эрхлэгч Л.Долгорсүрэн
6		Цагаан-уул	
7		Цэцэрлэг	
8		Мөрөн	
9	3-р хэсэг	Арбулаг	Багийн ахлагч: Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч хошууч Л.Бямбасүрэн Гишүүд: Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Б.Батбилгүүн Мал эмнэлгийн газрын улсын байцаагч Б.Мягмарсүрэн
10		Баянзүрх	
11		Улаан-уул	
12		Рэнчинлхүмбэ	
13		Цагааннуур	
14	4-р хэсэг	Алаг-эрдэнэ	Багийн ахлагч: Төлөвлөлт бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хошууч С.Ганболд Гишүүд: Мэргэжлийн хяналтын газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Б.Батдорж Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн Б.Сожидмаа
15		Чандмань-өндөр	
16		Цагаан-үүр	
17		Ханх	
18		Хатгал	
19	5-р хэсэг	Тосонцэнгэл	Багийн ахлагч: Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд боловсрол хүнсний хяналтын хэлтсийн дарга улсын ахлах байцаагч А.Үүрийнцолмон Гишүүд: Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах салбарын дарга, аврах ажиллагааны зааварлагч ахмад Х.Мөнхбат Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн Н.Цэнгэлзүсэм
20		Түнэл	
21		Их-уул	
22		Рашаант	
23		Тариалан	
24		Эрдэнэбулган	